



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 1/192
танай _____ -ны № _____ -т

**Г ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЕРӨНХИЙ Г
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.УУГАНБАЯР ТАНАА**

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг
хүргүүлж байна.

Хавсралт 20 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



006425030310



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүрээмарал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/030/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баянхонгор хот

2025 оны 02 дугаар сар 17

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК
Захирал Г.Саранчимэг
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com
Аудитор: О.Мандах
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асууда	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Албан шаардлага	16
5.2 Төлбөрийн акт	17
5.3 Зөвлөмж	17
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	188

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
АТБӨЯХ	Авто тээврийн болон өөрөө явах хэрэгсэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.УУГАНБАЯР ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/51
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүрээмарал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2024 онд 1,394,184.2 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,123,888.8 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 6,526.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 264,748.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх Хүрээмарал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны

5020260

гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 96.0 хувьтай тайлагнасныг 94.0 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн байна.

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	99,797,426.00	303,250,152.88
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	75,906,334.00	264,748,164.88
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	75,906,334.00	264,748,164.88
31210	Төгрөг	75,906,334.00	264,748,164.88
31211	Төрийн сангийн харилцах	75,906,334.00	264,748,164.88
33	АВЛАГА	0.00	45,643.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		45,643.00
35	БАРАА МАТЕРИАЛ	23,891,092.00	38,456,345.00
35100	Түүхий эд материал	3,240,000.00	3,240,000.00
35110	Тусгай зориулалттай материал	3,000,000.00	3,000,000.00
35130	Эм боох материал	240,000.00	240,000.00
35400	Хангамжийн материал	20,651,092.00	35,216,345.00
35420	Аж ахуйн материал	3,743,000.00	3,743,000.00
35470	Бусад хангамжийн материал	16,908,092.00	31,473,345.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,090,548,512.89	1,125,313,839.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,090,548,512.89	1,125,313,839.72
39200	Биет хөрөнгө	1,071,024,512.89	1,105,789,839.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,211,251,679.00	1,211,251,679.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(278,018,487.59)	(324,989,898.11)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	232,801,596.80	352,398,901.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(128,814,810.87)	(155,249,171.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	82,789,207.10	84,669,207.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(65,354,512.12)	(74,660,718.76)
39214	Бусад үндсэн хөрөнгө	46,741,537.12	46,741,537.12
39215	Хуримтлагдсан элэгдэл	(37,572,998.37)	(41,572,998.33)
39217	Ном	7,201,301.82	7,201,301.82
39300	Биет бус хөрөнгө	19,524,000.00	19,524,000.00
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(200,000.00)	(200,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	19,524,000.00	19,524,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,190,345,938.89	1,428,563,992.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	48473	68,098,909.67
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	48473	4,351,161.67
41300	Өглөг	48473	4,351,161.67
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	48473	3,377,161.67
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		974,000.00
41360	Бусад өглөг		63747748
41361	Байгууллагад төлөх өглөг		63,747,748.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,190,297,465.89	1,360,465,082.93
51	Засгийн газрын хувь оролцоо	290,170,245.35	290,170,245.35
51100	Засгийн газрын оруулсан капитал	290,170,245.35	290,170,245.35
51200	Хуримтлагдсан үр дүн	345,155,892.32	515,323,509.36
51210	Өмнөх үеийн үр дүн	345,155,892.32	345,155,892.32
51220	Тайлант үеийн үр дүн		170,167,617.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	554,971,328.22	554,971,328.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,190,345,938.89	1,428,563,992.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,225,062,106.00	1,343,912,058.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	361,989,206.00	25,238,658.00
120	Нийтлэг татварын бус орлого	361,989,206.00	25,238,658.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,304,904.00	584,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,304,904.00	584,100.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	360,684,302.00	21,784,305.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		2,870,253.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	863,072,900.00	1,318,673,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	733,476,100.00	1,174,083,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	733,476,100.00	1,174,083,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	129,596,800.00	144,590,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	129,596,800.00	144,590,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	903,692,778.87	1,173,744,440.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	903,692,778.87	1,173,744,440.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	850,648,323.08	1,145,133,095.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	511,913,005.10	755,292,482.33
210101	Үндсэн цалин	355,274,739.10	493,245,673.33
210102	Нэмэгдэл	129,546,920.00	237,375,168.00
210104	Урамшуулал	27,091,346.00	24,671,641.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,560,782.90	91,145,408.18
210201	Тэтгэврийн даатгал	45,758,561.32	61,986,158.16
210202	Тэтгэмжийн даатгал	5,173,974.60	7,783,430.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,219,099.15	3,933,145.70
210204	Ажилгүйдлийн даатгал	1,037,311.23	3,488,714.91
210205	Эрүүл мэндийн даатгал	10,371,836.60	13,953,959.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,934,944.21	119,063,454.50
210301	Гэрэл, цахилгаан	7,905,580.21	7,942,686.50
210302	Түлш, халаалт	95,029,364.00	111,120,768.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,655,300.00	4,150,500.00
210401	Бичиг хэрэг	8,655,300.00	3,938,500.00
210402	Тээвэр, шатахуун		212,000.00
2105	Нормативт зардал	38,748,000.00	54,180,000.00
210502	Хоол, хүнс	38,748,000.00	54,180,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,999,400.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	5,999,400.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,941,759.20	12,108,950.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,483,389.20	514,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,458,370.00	11,594,850.23
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,895,131.67	104,192,300.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,851,700.00	14,504,422.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2975900

Хүрээмарал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,043,431.67	86,711,978.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,044,455.79	28,611,345.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,382,000.00	22,084,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,629,500.00	22,084,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,752,500.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,662,455.79	6,526,845.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,662,455.79	6,526,845.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	321,369,327.13	170,167,617.04
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН(V)	8,291,165.78	
	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,291,165.78	
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(8,291,165.78)	
	НИЙТ ҮР ДҮН	313,078,161.35	170,167,617.04

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	864,387,046.00	1,319,257,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,314,146.00	584,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,314,146.00	584,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,304,904.00	584,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,234,904.00	584100
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	
120009	Бусад орлого	9,242.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	863,072,900.00	1,318,673,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	733,476,100.00	1,174,083,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	733,476,100.00	1,174,083,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	129,596,800.00	144,590,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	129,596,800.00	144,590,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	805,898,394.00	1,094,470,417.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	805,898,394.00	1,094,470,417.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	752,853,938.21	1,065,859,071.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	511,913,005.10	752,305,434.43
210101	Үндсэн цалин	355,274,739.10	490,258,625.43
210102	Нэмэгдэл	129,546,920.00	237,375,168.00
210104	Урамшуулал	27,091,346.00	24,671,641.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,081,644.90	90,849,410.41
210201	Тэтгэврийн даатгал	45,279,423.32	61,690,160.39
210202	Тэтгэмжийн даатгал	5,173,973.79	7,783,430.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,219,099.15	3,933,145.70
210204	Ажилгүйдлийн даатгал	1,037,312.04	3,488,714.91
210205	Эрүүл мэндийн даатгал	10,371,836.60	13,953,959.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,934,944.21	119,063,454.50
210301	Гэрэл, цахилгаан	7,905,580.21	7,942,686.50
210302	Түлш, халаалт	95,029,364.00	111,120,768.00
2105	Нормативт зардал	38,748,000.00	54,180,000.00
210502	Хоол, хүнс	38,748,000.00	54,180,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,999,400.00	14,900,000.00
210604	Урсгал засвар	5,999,400.00	14,900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,056,600.00	11,134,950.23

Хүрээмарал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	626,600.00	514,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,430,000.00	10,620,850.23
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,120,344.00	23,425,822.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,071,044.00	17,486,922.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,049,300.00	5,938,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,044,455.79	28,611,345.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,382,000.00	22,084,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,629,500.00	22,084,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,752,500.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,662,455.79	6,526,845.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,662,455.79	6,526,845.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	58,488,652.00	224,787,082.88
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	16,777,900.00	35,945,252.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,777,900.00	35,945,252.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,777,900.00	35,945,252.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,777,900.00	35,945,252.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(16,777,900.00)	(35,945,252.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	41,710,752.00	188,841,830.88
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	34,195,582.00	75,906,334.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	75,906,334.00	264,748,164.88

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,170,245.35	554,971,328.22	345,155,892.32	1,190,297,465.89
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	290,170,245.35	554,971,328.22	345,155,892.32	1,190,297,465.89
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
19	Тайлант үеийн үр дүн			170,167,617.04	170,167,617.04
20	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	290,170,245.35	554,971,328.22	515,323,509.36	1,360,465,082.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,394,184,200.0	1,123,888,823.62	270,295,376.4	80.6%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,394,184,200.0	1,123,888,823.62	270,295,376.4	80.6%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,368,067,000.0	1,101,804,323.6	266,262,676.4	80.5%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	970,431,600.0	752,305,434.43	218,126,165.6	77.5%

Хүрээмарал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	710,128,300.0	490,258,625.43	219,869,674.6	69.0%
210102	Нэмэгдэл	238,175,000.0	237,375,168.00	799,832.0	99.7%
210104	Урамшуулал	22,128,300.0	24,671,641.00	-2,543,341.0	111.5%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,304,100.0	90,849,410.41	30,454,689.6	111.5%
210201	Тэтгэврийн даатгал	82,486,700.0	61,690,160.39	20,796,539.6	74.8%
210202	Тэтгэмжийн даатгал	9,704,300.0	7,783,430.20	1,920,869.8	80.2%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,852,200.0	3,933,145.70	919,054.3	81.1%
210204	Ажилгүйдлийн даатгал	4,852,200.0	3,488,714.91	1,363,485.1	71.9%
210205	Эрүүл мэндийн даатгал	19,408,700.0	13,953,959.21	5,454,740.8	71.9%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,590,300.0	119,063,454.5	6,526,845.5	94.8%
210301	Гэрэл, цахилгаан	10,000,000.0	7,942,686.50	2,057,313.5	79.4%
210302	Түлш, халаалт	113,790,300.0	111,120,768.00	2,669,532.0	97.7%
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.0		1,800,000.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,000,000.0	19,000,000.0	0.0	100.0%
210604	Урсгал засвар	19,000,000.0	19,000,000.0	0.0	100.0%
2105	Нормативт зардал	58,081,600.0	54,180,000.0	3,901,600.0	93.3%
210502	Хоол, хүнс	58,081,600.0	54,180,000.0	3,901,600.0	93.3%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,655,200.0	13,830,950.2	824,249.8	94.4%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	514,100.0	514,100.0	0.0	100.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,141,100.0	13,316,850.2	824,249.8	94.2%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,004,200.0	52,575,074.1	6,429,126.0	87.9%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,065,300.0	46,636,174.1	6,429,126.0	87.9%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,938,900.0	5,938,900.0	0.0	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,117,200.0	22,084,500.0	4,032,700.0	84.6%
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,117,200.0	22,084,500.0	4,032,700.0	84.6%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,117,200.0	22,084,500.0	4,032,700.0	84.6%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,394,184,200.0	1,319,257,500.0	74,926,700.0	94.6%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,318,673,400.0	1,318,673,400.0	0.0	94.0%
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,174,083,100.0	1,174,083,100.0	0.0	94.0%
310002	Орон нутгийн төсвөөс санхүүжих	144,590,300.0	144,590,300.0	0.0	100.0%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	584,100.0	584,100.0	0.0	100.0%
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	584,100.0	584,100.0	0.0	100.0%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			0.0	
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	74,926,700.0	74,926,700.0	0.0	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		75,906,334.0	-75,906,334.0	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	75,906,334.0	264,748,164.9	188,841,830.9	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			0.0	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	0.0	
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	0.0	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32.0	30.0	2.0	

620001	Удирдах ажилтан	1.0	1.0	0.0	
620002	Гүйцэтгэх ажилтан	21.0	19.0	2.0	
620003	Үйлчлэх ажилтан	10.0	10.0	0.0	
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)		190	0.0	
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД		190	0.0	
630001	Төрийн өмчит ЕБС		190	0.0	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тодорхойлсон “Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба бүтэц зохион байгуулалттай 30 орон тоотой, 190 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” 25 дугаар тогтоолын хавсралт” Боловсролын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”
- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр журам батлах тухай” 39 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2024 оны 2 дугаар сарын 28-ний өдрийн “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 84, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил БНА-2025/030/НА-СТА-ТШЗ

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд Боловсролын ерөнхий газар болон аймгийн Боловсролын газраас хяналт, шинжилгээ, дотоод аудитын шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүрээмарал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-1 ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 238,217.9 мянган төгрөгөөр буюу 20.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	75,906.3	264,748.20	188,841.9
Авлага		45.60	45.6
Бараа материал	23,891.1	38,456.30	14,565.2
Үндсэн хөрөнгө	1,600,509.3	1,721,986.60	121,477.3
хуримтлагдсан элэгдэл	(509,960.8)	(596,672.80)	(86,712.0)
Нийт хөрөнгө	1,190,345.95	1,428,563.90	238,217.95
Өр төлбөр	48.50	68,098.90	68,050.40
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,190,297.50	1,360,465.00	170,167.50

БНА-2025/030/НА-СТА-ТШЗ



Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,190,346.00	1,428,563.90	238,217.90
---------------------------------------	--------------	--------------	------------

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Хүрээмарал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд оны эхэнд 75,906.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 264,748.2 мянган төгрөгийн өмнөх оноос 188,841.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 109,052.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 2,870.3 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлого авч үйл ажиллагаанд 97,357.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж бараа материалын үлдэгдэл 14,565.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 99,693.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авснаас Захирлын "Хөрөнгө бүртгэж, орлогод авах тухай "2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/17 дугаар тушаалаар 14,696.0 мянга, 2024 оны 01 сарын 08-ны өдрийн БАХСЕБС/011/001 тоот ерөнхий гэрээгээр "Мэксим консалтанг ХХК" 84,997.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, Боловсролын ерөнхий газраас 12,125.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, "Үндсэн хөрөнгөнд эзэмшигч тогтоох тухай" Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 25 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар Хүрээмарал сумын Соёлын төвийн хөрөнгөнд тушаал гарсан хөрөнгөөс 9,659.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэн авсан байна. Нийт 121,477.3 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Тайлант онд авлага 45.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн цалинтай холбоотой авлага байна.

Нийгмийн даатгалын шимтгэлд 742.2 мянган, ХХОАТатвар 228.5 мянган, ҮЭ-ийн өглөг 2,406.5 мянга, байгууллагад төлөх өглөг 64,721.7 мянган төгрөг нийт өглөг 68,050.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь дижитал кабинет байгуулж төлбөрийг хэсэгчлэн төлж байгаатай холбоотой өглөг 95.1 хувийг эзэлж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 170,167.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, 1,360,465.0 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 170,167.5 мянган төгрөгөөр нэмэгдэж 1,360,465.0 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,004,851.3 мянган төгрөгөөр төлөвлөж, зарлагыг 1,004,851.4 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас 173,387.2 мянган төгрөгөөр буурч 831,464.1 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 1394,184.2 мянган төгрөг болгож 562,720.1 мянган БНА-2025/030/НА-СТА-ТШЗ



төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь багш ажилчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 1,175,027.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч өмнөх оны харилцах дансны үлдэгдлээс 73,982.7 мянга, үйл ажиллагааны орлогоос 584.1 мянга, орон нутгийн төсвөөс 144,590.3 мянган төгрөг нийт 1,732,182.4 мянган төгрөгийн эх үүсвэртэй гүйцэтгэлээр 1,123,888.7 мянган төгрөгийг зарцуулж, 264,748.1 мянган төгрөг зарцуулаагүй харилцах дансанд үлдэгдлээр байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 144,590.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 95.4 хувь буюу 138,063.5 мянган төгрөгийг зарцуулж, 6,526.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	1,396.9	1,396.9	0.0	100.00%
2	80217- мэдээлэл технологийн үйлчилгээ	1014.0	0	1,014.0	0.00%
3	80312 Сургалт семинар	1,057.9	1,051.6	6.3	99.40%
4	81605 Эрүүл мэндийг дэмжих	1,528.2	1,525.0	3.2	99.79%
5	81801 Үдийн цай хөтөлбөр	26,117.2	22,084.5	4,032.7	84.56%
6	81844 гүнгийрүүлсэн сургалт	608.4	608.3	96.0	99.98%
7	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	30,421.6	30,389.3	32.3	99.89%
8	81823 Боловсролын байгууллагын багш	4,339.2		4,339.2	0.00%
9	81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	30,183.9	14,229.4	15,954.5	47.14%
10	81834 Боловсролын стандарт, сургалтын	914,232.5	716,269.8	197,962.7	78.35%
11	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	22,624.3	19,684.3	3.0	87.01%
12	81848 Сурах бичгийн түрээс	514.1	514.1	0.0	100.00%
13	81875 Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	2,257.6	1,473.9	783.7	65.29%
14	83602 ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	20.0	20.0	0.0	100.00%
15	80233 Хүүхэд хамгаалал	1,484.2	1,484.2	0.0	100.00%
16	81806 Дотуур байрны үйлчилгээ	211,793.9	175,094.1	36,699.8	82.67%
17	80112 Нийтлэг үйлчилгээ	144,590.3	138,063.5	6526.8	95.50%
	ДҮН	1,394,184.2	1,123,888.9	270,295.3	80.6

Эх сурвалж: 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хүрээмарал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүрээмарал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2025 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Б.Ууганбаяр, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Баттөмөр нар зурж, нярваар И.Цамбалхүндэв нар ажиллажээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийн зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг оны батлагдсан төсөв 1,389,170.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,891.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10,418.8 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,328.7 мянган төгрөгийн 25 гүйлгээ, зарлагын 228,139.6 мянган төгрөгийн 23 гүйлгээ, хуулийн хугацаанд мэдээлсэн байна. 2 мэдээг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

4.4.2 Худалдан авах ажиллагааны талаар

Тус сургууль нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил үйлчилгээ худалдан авах үнэлгээний хороог захирлын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/03, А/04 дүгээр тушаалаар 5 хүний бүрэлдхүүнтэй томилж дотуур байрны хүүхдийн хоол 54,104.4 мянган, үдийн хоолны 24,097.4 мянган төгрөгийн материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг харьцууллын аргаар зохион байгуулахаар 2024 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс 02 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл ажлын 5 хоногт багтан худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д тендерийн бичиг баримтыг байршуулсан байна.

Үдийн хоолны материал нийлүүлэх тендерийг 1 багц, дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлэх тендерийг 1 багц болгон зарласан байна

Үдийн хоолны материал нийлүүлэх 1 багц, дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлэх 1 багц тендерт Өгөөж марал ХХК компани шалгарч үдийн хоолны материал 24097.5 мянган төгрөг, хүүхдийн хоолны материал 54,104.4 мянган төгрөгийн бараа материал нийлүүлэх гэрээг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны тендер зарлах хугацаа хүртэл байгуулан ажилласан байна.

Худалдан авах гэрээний үнийн дүнг мөрдөн ажиллаж гэрээг дүгнэн ажилласан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баян ташаагийн эх” ХХК-ийн аудитор Б.Хандсүрэн гүйцэтгэж, 550.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон. Аудитаар өгсөн төлбөрийн актын хэрэгжилтийг тус байгууллагаас 2024.05.30-ны өдөр 26 дугаар албан бичгээр ирүүлж бүрэн биелүүлж ажиллажээ.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	550,0	1	550.0	100
Нийт дүн	1	550.0	1	550.0	100

Эх сурвалж: төлбөрийг 2024 оны 06.12 –ны төлбөрийн баримт

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын урамшууллыг олгохдоо “Өөрчлөлтгүй” гэж дүгнэгдсэн боловч төлбөрийг акт тогтоосон байхад нягтлан бодогч үндсэн цалингийн 3 сартай тэнцэх хэмжээний урамшуулал олгох тушаал гарган олгосон байна. Иймд дараагийн аудитаар дээрх урамшууллыг хавтгайруулан олгосон эсэх асуудлыг авч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,660.5 мянган төгрөгийн 4 зөрчил¹ илэрсэнд 2,309.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 781.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 489.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

Боловсролын байгууллагын онцлогоос шалтгаалж 2024 оны 6 дугаар сард олгосон ээлжийн амралтын мөнгийг нийгмийн даатгалын мэдээнд 6-8 саруудад мэдээлэхдээ 1 ажилтны 2,367.8 мянган төгрөгийн цалингаас суутган тооцсон нийгмийн даатгалын шимтгэл 568.3 мянга, ХХАОТ өглөг 197.5 мянга нийт 765.8 мянган төгрөгийн өглөгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээ, татварын мэдээнд тайлагнаагүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1” Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө” гэсэн заалтыг зөрчиж, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Амралтын мөнгөнөөс суутган тооцсон суутгалыг ХХОАТ-ын тайлан, Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд нөхөн мэдээлж холбогдох өглөгийг барагдуулах албан шаардлага өгөв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Боловсрол Шинжлэх ухааны яамны 2024 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 2/2772 дугаар албан бичгийг үндэслэн аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны 07 дугаар 09-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” Б/42 дугаар тушаалаар төсвийн шууд захирагчид балансын урамшуулал нэг сарын цалинтай тэнцэх 1,544.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6,4,1 -төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах мөн 16,5,5 - батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн шууд захирагч нарт балансын урамшуулал олгодог байдлыг таслан зогсоох зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Төлбөрийн акт

Сургуулийн нярав И.Цамбалхүндэвт 9,10,11 дүгээр саруудад 781.5 мянган төгрөгийн, нийгмийн ажилтан н.Гэрэлмаад 8 дугаар сард 80.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүй олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дах заалт “бодитой байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх хэсэг “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 “ хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүй олгосон 861.4 мянган төгрөгийг сургуулийн захирал, нягтлан бодогч нараар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.3 Зөвлөмж

1. АТӨЯХ-ийн албан татвартай холбоотой асуудал

Баянхонгор аймгийн Татварын газрын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 44 дугаар албан бичигт тус сургууль нь АТБӨЯХ-ийн албан татварын 489.0 төгрөгийн үлдэгдэлтэй хөндлөнгийн мэдээлэл ирүүлсэн байна. Гэвч тухайн байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд автомашин бүртгэлгүй бөгөөд санхүүгийн тайланд татварын өглөг тусгагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Татварын байгууллагатай тооцоо нийлж холбогдох өглөгийг шийдвэрлүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил								
Нярав ажилтай И.Цамбалхүндэвт 9,10,11 дүгээр саруудад 781,5 мянган төгрөгийн, нийгмийн ажилтан Гэрэлмаад 8 дугаар сард 80,2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүй олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх хэсэг "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.	1	861.7	1	861.7				
Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн өглөгийг 568,3 мянган төгрөгөөр, Хүн амын орлогын албан татварын өглөгийг 197.5 мянган төгрөгөөр дутуу тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.дэх заалттай нийцэхгүй байна.	1	765.8			1	765.8		
Татварын газрын хөндлөнгийн мэдээллээр АТБӨЯХ-ийн албан татварын 489.0 төгрөгийн өглөгтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна	1	489.0					1	489.0
Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2024.07.09 өдрийн Б/42 тоот тушаалаар төсвийн шууд захирагчид балансын урамшуулал нэг сарын цалинтай тэнцэх хэмжээгээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1., 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалттай нийцэхгүй байна.	1	1544.0			1	1544.0		
Нийт дүн	4	3660.5	1	861.7	2	2309.8	1	489.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 125/14225456/371А-2025/0201

Номгон

НА.СГА-ТШЗ

Г

Зөрчил арилгуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Боловсрол Шинжлэх ухааны яамны 2024 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 2/2772 дугаар албан бичгийг үндэслэн аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” Б/42 дугаар тушаалаар төсвийн шууд захирагчид балансын урамшуулал нэг сарын цалинтай тэнцэх 1,544,000 (Нэг сая таван зуун дөчин дөрвөн мянга) төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6,4,1 төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэсэн заалтыг зөрчсөн, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Төсвийн шууд захирагч нарт балансын урамшуулал олгодог байдлыг таслан зогсоох, зөрчлийг арилган биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны

5040247

дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.


2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүрээмарал сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Б. Ууганбаяр, нягтлан бодогч Б.Баттөмөр нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Б.МӨНХБАТ**

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: *О.МАНДАХ*

О.МАНДАХ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 56/14225456/БНА-2025/0301 Номгон
НА-СТА-ТШЗ

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сургуулийн нярав И.Цамбалхүндэвт 9-11 дүгээр сард 781500 /Долоон зуун наян нэгэн мянга таван зуун/ төгрөгийн, нийгмийн ажилтан н.Гэрэлмаад 8 дугаар сард 80236 /Наян мянга хоёр зуун гучин зургаан/ төгрөгийн нийт 861,736 /Найман зуун жаран нэгэн мянга долоон зуун гучин зургаан /төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүй олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дах заалт “бодитой байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх хэсэг “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 “ хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчиж, Үнэн ба зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь

5050117

“Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Тушаал шийдвэргүй олгосон 861,736 /Найман зуун жаран нэгэн мянга долоон зуун гучин зургаан /төгрөгийг сургуулийн захирал, нягтлан бодогч нараар төлүүлж төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2.Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүрээмарал сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Б.Ууганбаяр, нягтлан бодогч Б.Баттөмөр нарт хариуцуулав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:  О.МАНДАХ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 12Н/14225756/67НА-2025/020/ Номгон
НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүрээмарал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Боловсролын байгууллагын онцлогоос шалтгаалж 2024 оны 6 дугаар сард олгосон ээлжийн амралтын мөнгийг нийгмийн даатгалын мэдээнд 6-8 саруудад мэдээлэхдээ Б.Мөнхзаяагийн 2,367,816.0 төгрөгийн цалингаас суутган тооцсон нийгмийн даатгалын шимтгэл 568,275.84 /Таван зуун жаран найман мянга хоёр зуун далан таван төгрөг наян дөрвөн мөнгө/, ХХОАТ 197,552 /Нэг зуун ерэн долоон мянга таван зуун тавин хоёр/ төгрөгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээ, татварын мэдээнд тайлагнаагүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1" Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө" гэсэн заалтыг зөрчиж, ННББОУС-1, "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа,

5040246

зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1.ХХОАТ-ын тайлан, Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 1 ажилтны цалинг нөхөн мэдээлж холбогдох өглөгийг барагдуулж, зөрчлийг арилган биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүрээмарал сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Б. Ууганбаяр, нягтлан бодогч Б.Баттөмөр нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Б.МӨНХБАТ**

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: *О.МАНДАХ*

О.МАНДАХ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно